

Golomt Capital®

Валютын зах зээлийн ТОЙМ

ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК- Д БЭЛТГЭВ

2022.05.16

*Дотоодын зах зээл
Олон улсын зах зээл*

ДОТООДЫН ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛИЙН СУУРЬ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2022 он 05 сарын 16


| Ханшийн өөрчлөлт | Албан ханш | Долоо хоног | Оны эхнээс | Жил |
|---------------------|------------|-------------|------------|--------|
| | 3,111.84 | 0.385% | 9.226% | 9.196% |

Товч дүгнэлт:

Өнгөрсөн 7 хоногт ам.долларын ханш төгрөгийн эсрэг 0.385 хувиар чангарлаа. Төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг хангахаар Төв банк интервенцийг нэмэгдүүлж байгаа ч эрэлт өндөр байгаа тул ам.долларын ханш төгрөгийн эсрэг чангарсаар байна.

Монголбанкны дуудлага худалдаа:

Өнгөрсөн 7 хоногт Монголбанк банкнуудын 122.2 сая ам.доллар худалдан авах хүсэлтийг зах зээлд нэг ханшаар нийлүүлсэн байна. Харин банкнууд 10 сая ам.долларын своп хэлцэл байгуулах саналыг 2 удаа ирүүлсэн бол Монголбанк биелүүлээгүй байна.



Гадаад худалдаа:

2022 оны 4 сарын байдлаар Монгол Улсын гадаад худалдаа 199 сая ам.долларын ашигтай гарлаа. Ингэснээр 2022 оны эхний 4 сард цэвэр экспорт 450 сая ам.доллар, бараа эргэлт 5.1 тэрбум ам.долларт хүрсэн байна. Гадаад худалдааны тэнцэл эерэг гарах нь тухайн орны валютын ханш бусад валютуудын эсрэг чангарах нөхцөлийг бүрдүүлдэг



Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

ОЛОН УЛСЫН ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2022 оны 5 сарын 16

| | Хаалтын ханш | 7 хоног | 1 сар | 1 жил |
|--------|--------------|---------|---------|---------|
| DXY | 104.528 | -0.81% | 3.35% | 15.96% |
| EURUSD | 1.0410 | -1.36% | -3.66% | -14.32% |
| USDCNY | 6.7877 | 0.88% | 6.87% | 5.43% |
| USDRUB | 64.5450 | -7.00% | -19.31% | -12.54% |
| USDJPY | 129.29 | -0.75% | 2.31% | 18.39% |
| AUDUSD | 0.6940 | -0.2% | -6.16% | -10.59% |

DXY ханшийн хөдөлгөөн:

Өнгөрсөн 7 хоногт ам.долларын ханш олон улсын зах зээл дээр голлох валютуудын эсрэг бага зэрэг чангарлаа. Ханшийн өөрчлөлтөд дараах хүчин зүйлс голлон нөлөөлөв.

- Өнгөрсөн 7 хоногт АНУ-ын инфляцын тоон мэдээлэл шинжээчдийн таамаглалаас өндөр гарлаа. Тодруулбал, АНУ-ын 4 сарын хэрэглээний үнийн индекс өнгөрсөн оноос 8.3 хувиар буюу шинжээчдийн таамаглаж байсан 8.1 хувиас өндөр гарсан байна.
- Хэрэглээний үнийн индекс 8.3 хувийн өсөлттэй гарсан учраас Холбооны нөөцийн сангийн тэргүүн Jerome Powell ирэх саруудын хурлаар бодлогын хүүг 75 нэгжээр нэмэгдүүлэх эсэх талаар хэлэлцэнэ хэмээлээ. Jerome Powell өмнө нь 50 нэгжээс өндөр дүнгээр бодлогын хүүг нэмэхгүй гэж мэдэгдэж байсан ч инфляцын өсөлт нь түүнийг бодлогын хүүг эрчтэй нэмэгдүүлэх талаар дахин бодоход хүргэлээ.

График 3 : DXY /ам.долларын индекс/-ийн 7 хоногийн лаа



Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.